**МОНГОЛ УЛСЫН**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ**
**САЙДЫН ТУШААЛ**

2004 оны 2 сарын 2 өдөр    Дугаар 25    Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Минжүүр овогтой Эрдэнэбатыг 2003-2004 оны хичээлийн жилээс Сингапур улсын Раффлес Академийн магистрантурт эрх зүйн чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 326 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2002.326 тушаал кодификаци хийсэн

САЙД    А.ЦАНЖИД

0000057